

ТУЗ-ийн 2023 оны 09-р сарын 12-ны өдрийн
23/001 тоот тогтоолын хавсралт

“МЭЙН СТРИТ ФИНАНС ББСБ” ХХК



F I N A N C E

**МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ,
ТАЙЛАГНАЛЫН ЖУРАМ**

2023 он

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ,

ТАЙЛАГНАЛЫН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Компанийн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжийн бусад актын хүрээнд "МЭЙН СТРИТ ФИНАНС ББСБ" ХХК-ийн хуулиар зөвшөөрөгдсөн мэдээллийг нийтэд түгээх, сурталчлах, буруутай этгээдэд хариуцлага тооцох зэрэг харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- 2.1 Хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх
2.2 Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл ил тод, нээлттэй байх
2.3 Мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа шуурхай, хялбар байх
2.4 Мэдээлэл, үйлчилгээ нь ойлгомжтой, үнэн зөв, бүрэн байх
2.5 Мэдээллийг ашиглах үйл ажиллагаанд хүн, хуулийн этгээд эрх тэгш байх

ГУРАВ. МЭДЭЭЛЭЛ НИЙЛҮҮЛЭХ, НИЙТЭД ИЛ

БОЛГОХ МЭДЭЭЛЛҮҮД

- 3.1 Компанийн зүгээс дараах мэдээллийг олон нийтэд үйл ажиллагаагаа танилцуулах, бүтээгдэхүүн үйлчилгээний талаар зөв ойлголт төрүүлэх, хөрөнгө оруулагч татах зорилгоор нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сайт, веб хуудас, олон нийтийн радио, телевиз зэргээр мэдээллийг нийтэд нийлүүлж ил болгож болно. Үүнд:
- 3.1.1 Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;
- 3.1.2 Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;
- 3.1.3 Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажааллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;
- 3.1.4 Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;
- 3.1.5 Хуульд өөрөөр заагаагүй бол үйл ажиллагааны статистик мэдээлэл;
- 3.1.6 Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;
- 3.1.7 Аудитын байгууллагаар баталгаажсан хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;
- 3.1.8 Хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цаасны мэдээлэл;
- 3.1.9 Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, хэлбэр, хураамж, хүү, шимтгэлийн хэмжээ, төлбөр төлөх дансны дугаар;
- 3.1.10 Шаардлагатай тохиолдолд компанийн эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл;
- 3.1.11 Хууль тогтоомжид заасан бусад.

ДӨРӨВ. МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙГ ХАНГАХ,
ЗӨВШӨӨРӨЛ, ХОРИГЛОХ ЗҮЙЛ.

- 4.1 Мэдээллийн эзнээс зөвшөөрөл авахдаа дараах нөхцөлийг танилцуулна.
- 4.1.1 Мэдээлэл авах зорилго;
 - 4.1.2 Мэдээлэл авагч нь хувь хүн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, холбоо барих хаяг, харилцах утасны дугаар;
 - 4.1.3 Мэдээлэл хариуцагчийн нэр, холбоо барих хаяг, харилцах утасны дугаар;
 - 4.1.4 Авах мэдээллийн жагсаалт, мэдээлэл авах хэлбэр;
 - 4.1.5 Мэдээлэл боловсруулах, ашиглах хүрээ, хадгалах хугацаа;
 - 4.1.6 Мэдээллийг ил болгох эсэх /Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн хүрээнд/;
 - 4.1.7 Мэдээллийг бусдад дамжуулах эсэх Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн хүрээнд/;
 - 4.1.8 Хуульд өөрөөр заагаагүй бол гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад цуглуулсан мэдээллийг нийтэд тараахыг хориглоно.

ТАВ. ТАЙЛАГНАЛ.

- 5.1 Компани нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан мэдээллийн ил тод байдлыг хэрэгжүүлсэний үндсэн дээр үйл ажиллагаанд гарсан өөрчлөлтийн талаарх мэдээллийг ТУЗ-д жилийн эцсээр тайлагнаж байх.
- 5.2 Нийтэд хагас жил болон бүтэн жилийн санхүүгийн аудитлагдсан тайланг цахим сүлжээнд байршуулж байх.
- 5.3 Хөрөнгө оруулалт татах, санхүүжүүлэх зорилгоор гаргасан, үнэт цаасны тоо ширхэг, нэгжийн үнэ, татан төвлөрүүлсэн хөрөнгийн талаар нийтэд ил тодоор тайлагнаж байх.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ.

- 6.1 Энэхүү журмыг зөрчсөний улмаас гуравдагч этгээдэд хохирол учирсан бол зөрчлийн шинжээс нь хамааруулан Хөдөлмөрийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуульд заасан хариуцлагыг хүлээлгэхээр холбогдох байгууллагад мэдэгдэнэ.